

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/008/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-22
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. Аудитын тайлан	23-26
4.1 Ерөнхий зүйл	23
4.2 Материаллаг байдал	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
5. Аудитын илрүүлэлт	27-34
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	35-36

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

2025.03.25 № СЭА-2025/008/КА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс 170,344.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- ИТХ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин Вишн Визуал студи ХХК-аар ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааг сурталчилсан контент, дүрс бичлэг бэлтгүүлсний төлбөрт 20,000.0 мянган төгрөг, бэлэг дурсгалын зориулалт бүхий 1.5 мянган ширхэг цаасан торны илүүдэл нөөц үүсгэж 5,250.0 мянган төгрөг зэрэг нийт 25,250.0 мянган төгрөгийг зарцуулсан,

- ЗДНХ, ЗДТГ-аас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин түүх соёлын дурсгалт болон байгалийн цогцолбор газруудын видео бичлэг хийлгэхэд 4,879.6 мянган төгрөг, ИТХ-ын хүндэтгэлийн хуралдааны бэлэг дурсгалд 2,500.0 мянган төгрөг зэрэг нийт 7,379.9 мянган төгрөгийг зарцуулсан,
- ИТХ нь 22,000.0 мянган төсөвт өртөг бүхий “2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн тайлан бэлтгэх” төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 2 хувааж, худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн,
- ИТХ нь төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиг арвилан хэмнэлтгүйгээр 56,963.8 мянган төгрөгийн зарцуулалт гаргасан,
- ИТХ нь сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдаагүй атал төлөөлөгчид санал гаргаж, хэлэлцэн, баталсан гэх үндэслэлээр сумын Ардчилсан намын хороо болон төлөөлөгч Г.Амарбаясгалан нарт 14,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон,
- ИТХ, ЗДТГ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр, тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 4,129.6 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- Цалингийн зардлын батлагдсан төсвөөс ИТХ 800.0 мянган төгрөг, ЗДТГ 3,300.0 мянган төгрөг зэрэг нийт 4,100.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг тооцож олгосон,
- ЗДТГ нь аймгийн Засаг даргын 2015 оны А/475 дугаар захирамжаар батлагдсан орон тоонд батлагдаагүй 2 ажлын байранд томилгоо хийж, 61,268.1 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан,
- ЗДТГ нь 2 албан хаагчид олгосон урамшууллаас ХХОАТ-ын 1,011.5 мянган төгрөг суутгаагүй, 39 албан хаагчид 2,654.1 мянган төгрөгийн урамшуулал илүү тооцож олгосон байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, 15.1.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.5, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 34 дүгээр зүйлийн 34.6.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 30 арга хэмжээг санхүүжүүлэхээр **12,598,412.2** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 8,151,127.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 4,147,284.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 300,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **10,824,934.5** мянган төгрөг буюу **85.9** хувьтай байгаа нь урсгал зардлыг 458,955.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,104,001.5 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 210,520.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын ахлах байцаагчийн 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 05/32-01 дүгээр төлбөрийн актаар Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хугацаа хэтрэлтийн алдангийг нөхөн төлүүлэхээр тогтоосон 178,958.7 мянган төгрөгийн 50 хувийг буюу **89,479.4** мянган төгрөгийг тус сангийн төсвөөс барагдуулсан нь сангийн эх үүсвэрийг мөн хэмжээгээр хорогдуулж, зорилго зориулалтыг алдагдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 1.5 дахь “*Сангийн хөрөнгө нь суманд хоршоонд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, сургалт зохион байгуулах, хяналт тавих, авлага барагдуулах, урамшуулал олгоход зориулагдана*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар сумын Засаг дарга нь тайлант онд 17 зорилт, 272 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,855,297.8	4,394,758.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	707,198.3	3,311,566.2
33	АВЛАГА	1,047,168.8	951,417.5
35	БАРАА МАТЕРИАЛ	100,930.7	131,775.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,902,581.5	3,267,556.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,902,581.5	3,267,556.7
39200	Биет хөрөнгө	1,682,553.4	3,020,502.5
39300	Биет бус хөрөнгө	220,028.0	247,054.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,757,879.3	7,662,315.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,876.8	5,611.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,876.8	5,611.8
41300	Өглөг	6,876.8	5,611.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,751,002.5	7,656,703.7
51	Засгийн газрын хувь оролцоо	3,751,002.5	7,656,703.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	324,958.0	324,958.0
51200	Хуримтлагдсан үр дүн	3,333,393.2	7,239,094.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,651.3	92,651.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,757,879.3	7,662,315.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,539,642.8	17,440,298.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,893,658.0	14,133,316.8
110	Орлогын албан татвар	8,383,821.0	13,553,194.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	8,889,474.3	14,205,273.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(505,653.3)	(652,079.5)
113	Хөрөнгийн албан татвар	219,507.6	283,031.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	290,329.4	297,091.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	803,852.2	2,305,729.4
120	Нийтлэг татварын бус орлого	803,852.2	2,305,729.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	842,132.7	1,001,252.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,617,785.1	12,360,608.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,990,419.8	10,262,097.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,425,981.1	7,630,308.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,190,224.7	2,008,073.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,772.4	241,286.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,700.4	2,087,669.5
2104	Хангамж, бараа материалын зардал	74,234.4	87,312.8
2105	Нормативт зардал	900.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,358.0	319,386.6
2107	Томилолт, зочны зардал	16,447.6	23,652.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,205,093.3	29,131.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	626,250.4	2,833,794.4
212	ТАТААС	109,844.4	104,815.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,454,594.3	2,526,973.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,627,365.3	2,098,511.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	921,857.8	5,079,689.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	480.5	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	899,316.0	1,173,988.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	23,022.3	3,905,701.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,727,980.2	-	3,727,980.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,727,980.2	-	3,727,980.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	23,022.3	-	23,022.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,751,002.5	-	3,751,002.5
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,751,002.5	-	3,751,002.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,751,002.5	-	3,751,002.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	3,905,701.2	-	3,905,701.2
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,656,703.7	-	7,656,703.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,304,421.8	15,818,433.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,893,658.0	14,133,316.8
110	Орлогын албан татвар	8,383,821.0	13,553,194.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	8,889,474.3	14,205,273.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(505,653.3)	(652,079.5)
113	Хөрөнгийн албан татвар	219,507.6	283,031.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	290,329.4	297,091.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	159,630.9	167,202.8
1181	Газрын төлбөр	130,588.9	129,344.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	109.6	543.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	568,631.1	683,864.9
120	Нийтлэг татварын бус орлого	568,631.1	683,864.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	842,132.7	1,001,252.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,830,322.3	10,048,659.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,830,322.3	10,048,659.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,265,883.6	7,416,871.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,189,860.0	2,008,872.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,510.6	241,446.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,700.4	2,096,319.5
2104	Хангамж, бараа материалын зардал	76,984.4	84,458.8
2105	Нормативт зардал	900.0	820.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91,260.0	309,763.4
2107	Томилолт, зочны зардал	16,447.6	23,652.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,206,531.8	31,841.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	461,688.9	2,619,695.5
212	ТАТААС	109,844.4	104,815.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,454,594.3	2,526,973.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,474,099.4	5,769,773.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,790,772.9	3,075,926.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,790,772.9	3,075,926.6
2200	Дотоод эх үүсвэрээр	2,790,772.9	3,075,926.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,790,772.9)	(3,075,926.6)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(200,000.0)	(89,479.4)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.0	89,479.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(516,673.4)	2,604,367.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,223,871.7	707,198.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	707,198.3	3,311,566.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,598,412.2	10,824,934.5	1,773,477.7	85.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,151,127.5	7,692,172.0	458,955.5	94.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,845,300.6	7,438,520.4	406,780.2	94.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,241,651.0	2,008,872.2	232,778.8	89.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	280,206.1	241,446.7	38,759.4	86.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,180,744.6	2,096,319.5	84,425.1	96.1
2104	Хангамж, бараа материалын зардал	92,609.6	84,458.8	8,150.8	91.2
2105	Нормативт зардал	820.3	820.3	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	336,758.5	326,913.2	9,845.3	97.1
2107	Томилолт, зочны зардал	31,603.4	23,652.8	7,950.6	74.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил; үйлчилгээний төлбөр, хураамж	43,145.4	31,841.9	11,303.5	73.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,637,761.7	2,624,195.0	13,566.7	99.5
212	ТАТААС	104,815.2	104,815.2	-	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	104,815.2	104,815.2	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,011.7	148,836.4	52,175.3	74.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	14,000.0	14,000.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	187,011.7	134,836.4	52,175.3	72.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,147,284.7	3,043,283.1	1,104,001.6	73.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	300,000.0	89,479.4	210,520.7	29.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,598,412.2	10,941,696.2	1,656,716.0	86.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,071,515.3	10,829,655.6	1,241,859.7	89.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	526,896.9	112,040.7	414,856.2	21.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	239,963.7	(239,963.7)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	356,725.5	(356,725.5)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	140.0	140.0	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4.0	4.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	68.0	68.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	68.0	68.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		10,994,038.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		10,994,038.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,994,038.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		10,994,038.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		10,994,038.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,994,038.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,994,038.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,789,008.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		810,030.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч *Ицаашид Сүхбаатар сумын ТТЗ гэх* нь “Хууль тогтоомж төр засгийн бусад шийдвэрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн оновчтой бодлого зохицуулалтаар ханган төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэн, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэн ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймаг, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, аймаг, сумын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах,
- Эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулах,
- Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлэх,
- Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 443,184.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 379,033.3 мянган төгрөгийн 9 албан шаардлага, 64,150.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сүхбаатар сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,904,436.2 мянган төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	707,198.3	3,311,566.2	2,604,367.9
Авлага	1,047,168.8	951,417.5	(95,751.3)
Бараа материал	100,930.7	131,775.1	30,844.4
Үндсэн хөрөнгө	1,902,581.5	3,267,556.7	1,364,975.2
Нийт хөрөнгө	3,757,879.3	7,662,315.5	3,904,436.2
Өр төлбөр	6,876.8	5,611.8	(1,265.0)
Засгийн газрын хувь оролцоо	3,751,002.5	7,656,703.7	3,905,701.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,757,879.3	7,662,315.5	3,904,436.2

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудыг тус бүрээр нь тайлбарлан доор харуулав.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,311,566.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,604,367.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	707,198.3	3,311,566.2	2,604,367.9
Төгрөг	707,198.3	3,311,566.2	2,604,367.9
Төрийн сангийн харилцах	707,198.3	3,311,566.2	2,604,367.9
Дүн	707,198.3	3,311,566.2	2,604,367.9

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 2,954,840.8 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 301,414.5 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 55,310.9 мянган төгрөг ХХС-ийн дансанд тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 951,417.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 95,751.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	502.0	785.6	283.6
Татаас, санхүүжилтийн авлага	-	70.5	70.5
Зээлийн хүүгийн авлага	67,784.6	67,784.6	-
Байгууллагаас авах авлага	19,656.0	7,384.1	(12,271.9)
Хувь хүмүүсээс авах авлага	4,212.9	4,212.9	-
Хувь хүмүүст олгосон зээл	955,013.4	871,179.8	(83,833.6)
Дүн	1,047,168.9	951,417.5	(95,751.4)

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна.
Үүнд:

- Тайлант онд үүссэн сумын ЗДТГ-ын 269.6 мянган төгрөгийн цалингийн болон НДШ-ийн авлага, ИТХ-ын 14.0 мянган төгрөгийн НДШ-ийн, 1,610.0 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага, Ойн ангийн 70.5 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага зэрэг нийт 1,964.1 мянган төгрөгийн авлагыг нэмж бүртгэсэн,
- ХХС-ийн зээлийн 871,179.8 мянган төгрөг, зээлийн хүүгийн 67,784.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл тайлагнагдсан байна.

Авлагын дансны үлдэгдэлд хугацаа хэтэрсэн 559,652.4 мянган төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- ХХС-ийн зээлийн хүүгийн 542,667.7 мянган төгрөгийн авлага,
- ХХС-ийн зээлийн 16,984.7 мянган төгрөгийн авлага байна.

Тайлант онд хугацаа хэтэрсэн /2011-2021 оны хооронд зээл авсан/ 559,652.4 мянган төгрөгийн зээлийн авлагаас 79,443.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 131,775.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 30,844.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	39,096.9	66,677.1	27,580.2
Тусгай зориулалттай материал	39,096.9	66,677.1	27,580.2
Хангамжийн материал	61,833.8	65,098.0	3,264.2
Бичиг хэргийн материал	2,027.6	2,371.4	343.8
Аж ахуйн материал	35,350.4	33,643.2	(1,707.2)
Сэлбэг хэрэгсэл	1,912.0	-	(1,912.0)
Түлш, шатах тослох материал	5,000.0	2,952.0	(2,048.0)
Бусад хангамжийн материал	10,543.8	19,131.4	8,587.6
Биологийн хөрөнгө	7,000.0	7,000.0	-
Дүн	100,930.7	131,775.1	30,844.4

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд 215,191.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, 23,488.3 мянган төгрөгийн боодлын өвс, хивэг, ногоон тэжээлийг үнэ төлбөргүй хүлээн авсан, 217,802.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 883,413.0 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, бусад хангамжийн материалын дансаар дамжуулан хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлснээс тус тус шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,267,556.7 мянган төгрөг болж,

өмнөх оноос 1,364,975.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,682,553.5	3,020,502.5	1,337,949.0
Барилга, байгууламж, орон сууц	1,138,182.8	1,556,841.1	418,658.2
Хуримтлагдсан элэгдэл	(152,212.6)	(168,093.7)	(15,881.1)
Авто-тээврийн хэрэгсэл	165,395.8	334,032.1	168,636.4
Хуримтлагдсан элэгдэл	(100,378.5)	(124,152.7)	(23,774.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	230,832.7	291,639.3	60,806.6
Хуримтлагдсан элэгдэл	(80,567.1)	(127,317.7)	(46,750.6)
Тавилга, аж ахуйн эд хогшил	140,049.1	123,579.9	(16,469.2)
Хуримтлагдсан элэгдэл	(71,380.7)	(64,943.0)	6,437.8
Зам, гүүрийн байгууламж	145,412.4	145,412.4	-
Хуримтлагдсан элэгдэл	(60,255.6)	(74,484.8)	(14,229.2)
Бусад үндсэн хөрөнгө	441,548.6	1,296,449.5	854,901.0
Хуримтлагдсан элэгдэл	(114,138.3)	(168,525.0)	(54,386.7)
Ном	65.0	65.0	-
Биет бус хөрөнгө	220,028.0	247,054.3	27,026.2
Програм хангамж	2,682.5	2,282.5	(400.0)
Хуримтлагдсан элэгдэл	(2,345.5)	(2,195.2)	150.2
Бусад биет бус хөрөнгө	219,691.0	246,967.0	27,276.0
Дүн	1,902,581.5	3,267,556.7	1,364,975.2

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлтүүд гарсан байна.
Үүнд:

- Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвөөр 107,320.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан,
- Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” 15 дугаар тогтоолын дагуу 317,024.4 мянган төгрөгийн Ахмадын сувиллын барилга, газар, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг сумын ЗДТГ-т шилжүүлэн авсан,
- Онцгой байдлын Ерөнхий газрын дэргэдэх Гал унтраах 185 дугаар ангиас 72,000.0 мянган төгрөгийн фургон автомашин шилжүүлэн авсан,
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 350,000.0 мянган төгрөгийн Багийн хөгжлийн төвийн байр, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар ИТХ-д 42,000.0 мянган төгрөгийн автомашин, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 50,000.0 мянган төгрөгийн тоглоомын талбай зэрэг төсөл, арга хэмжээг тус тус комиссын актаар хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан,
- Сумын ИТХ-ын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор 15,156.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 26,171.6 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 14,276.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 400,0 мянган төгрөгийн Си Ти Эс санхүүгийн программ зэрэг нийт 56,003.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан зэргээс шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 5,611.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,265.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	707.6	32.7	(675.0)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,555.5	2,555.5	-
Байгууллагад төлөх өглөг	2,737.7	2,147.7	(590.0)
Хувь хүмүүст төлөх өглөг	876.0	876.0	-
Дүн	6,876.8	5,611.8	(1,265.0)

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

ОНЕО-ын 2,759.3 мянган төгрөг, ХХС-ийн 2,476.0 мянган төгрөг, Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн 343.9 мянган төгрөг, ЗДТГ-ын 32.6 мянган төгрөг зэрэг нийт 5,611.8 мянган төгрөгийн өглөг бүртгэгдсэн байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,656,703.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,905,701.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	324,958.0	324,958.0	-
Хуримтлагдсан үр дүн	3,333,393.2	7,239,094.5	3,905,701.2
Өмнөх үеийн үр дүн	3,310,370.9	3,333,393.2	23,022.3
Тайлант үеийн үр дүн	23,022.3	3,905,701.2	3,882,678.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,651.3	92,651.3	-
Дүн	3,751,002.5	7,656,703.7	3,905,701.2

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Сүхбаатар сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 98 дугаар тогтоолоор тайлант онд 12,516,243.6 мянган төгрөгийн татварын орлого, 440,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, өөрийн орлого 46,000.0 мянган төгрөг, нийт **13,002,243.6** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт

төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **14,733,348.1** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 13.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	12,516,243.6	14,133,316.8	1,617,073.2	112.9
Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого	10,970,944.6	11,601,009.2	630,064.6	105.7
Үйл ажиллагааны орлого	1,107,000.0	1,404,551.3	297,551.3	126.9
Хөрөнгийн орлого	390,000.0	732,037.9	342,037.9	187.7
Хөрөнгө борлуулсны орлого	240,000.0	467,675.3	227,675.3	194.9
ХХОАТ-ын буцаалт	(652,079.5)	(652,079.5)	-	100.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	148,000.0	265,944.8	117,944.8	179.7
Бууны албан татвар	5,000.0	4,950.5	(49.5)	99.0
Малд ногдуулах албан татвар	31,277.5	12,136.5	(19,141.0)	38.8
Улсын тэмдэгтийн хураамж	75,000.0	61,045.8	(13,954.2)	81.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000.0	-	(1,000.0)	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	120,000.0	106,156.9	(13,843.1)	88.5
Газрын төлбөр	60,000.0	129,344.2	69,344.2	215.6
Дуудлага худалдаа	20,000.0	-	(20,000.0)	-
Ойн нөөц ашигласны төлбөр	-	97.9	97.9	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	136.0	136.0	
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	71.0	110.0	39.0	154.9
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	30.0	200.0	170.0	666.7
Татварын бус орлого	486,000.0	600,031.3	114,031.3	123.5
Торгуулийн орлого	380,000.0	484,173.0	104,173.0	127.4
Бусад орлого	60,000.0	87,651.2	27,651.2	146.1
Төсөвт байгууллагын өөрийн орлого	46,000.0	28,207.1	(17,792.9)	61.3
Нийт орлогын дүн	13,002,243.6	14,733,348.1	1,731,104.5	113.3

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого 630,064.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 297,551.3 мянган төгрөг, хөрөнгийн орлого 342,037.9 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 227,675.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Тайлант онд Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор 11,601,009.2 мянган төгрөгийн орлого төвлөрч, 630,064.6 мянган төгрөгөөр давж биелсэн,
- **Үйл ажиллагааны орлого:** “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 1072 хувьцааны 2024 оны ногдол ашгийг иргэдэд тараасантай холбоотойгоор 1,404,551.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, 297,551.3 мянган төгрөгөөр давж биелсэн,

- **Хөрөнгийн орлого:** Аймгийн дүнгээр 16 сумын 732,037.9 мянган төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлого тус суманд төвлөрснөөс шалтгаалж, 342,037.9 мянган төгрөгөөр давж биелсэн,
- **Хөрөнгө борлуулсны орлого:** Тус сумын 7 багт шинээр барилга, орон сууц ашиглалтад орсонтой холбоотойгоор 467,675.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, 227,675.3 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Тасарсан орлого:

- **Малд ногдуулах албан татвар:** Сумын малчин болон мал бүхий иргэдийн төлбөр төлөлт хангалтгүйгээс 12,136.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, 19,141.0 мянган төгрөгөөр тасарсан,
- **Улсын тэмдэгийн хураамж:** Сонгуулийн тухай хуулийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөнийг 4 сарын хугацаатай зогсоосонтой холбоотойгоор 61,045.8 мянган төгрөгийн орлого төвлөрч, 13,954.2 мянган төгрөгөөр тасарсан,
- **Бусад орлого:** Алтанбулаг сумын ИТХ-аар хэрэглээний мод бэлтгэх хуваарийг батлаагүй учраас Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн талбай тусгаарлалтаар 19,007.1 мянган төгрөгийн орлого төвлөрч, 25,992.9 мянган төгрөгөөр тасарсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 10,103,096.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 142 дугаар тогтоолоор сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,299,989.5 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 975,948.8 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 87 дугаар тогтоолоор сумын төсвийн орлогыг 11,672,937.8 мянган төгрөг, өөрийн орлогыг 46,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 640,761.7 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвараас санхүүжих 36,547.3 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 302,100.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, эх үүсвэр болон нийт зарлагыг 13,674,295.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгож, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,078,147.8 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 50,225.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 23-ний өдрийн 98 дүгээр тогтоолоор дараах төсвийн тодотголыг хийсэн байна. Үүнд:

Эх үүсвэрийг **1,302,253.9** мянган төгрөгөөр нэмэгдүүлж:

- Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлогыг 304,746.0 мянган төгрөгөөр,
- ХХОАТ-ын буцаалтыг 101,426.2 мянган төгрөгөөр,

- ОНХС-гийн эх үүсвэрийг 50,225.6 мянган төгрөгөөр,
- Үйл ажиллагааны орлогыг 1,048,708.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,

Зарлагыг **224,106.1** мянган төгрөгөөр нэмэгдүүлж:

- Сумын ОНХС-ийн зардлыг 50,225.7 мянган төгрөгөөр,
- Сургууль, цэцэрлэгийн халаалтын зардлыг 154,074.5 мянган төгрөгөөр,
- Сумын ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын зардлыг 54,935.90 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Сумын ИТХ-ын зардлыг 35,130.0 мянган төгрөгөөр бууруулсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 30 арга хэмжээг санхүүжүүлэхээр **12,598,412.2** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 8,151,127.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 4,147,284.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 300,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 11,045,340.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 240,933.3 мянган төгрөгийг ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, ОНХС-аас 1,026,174.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 46,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 239,963.6 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:

<i>/мянган төгрөгөөр/</i>					
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сэ. Сү. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	574,843.8	544,175.2	30,668.6	94.7
2	Сэ. Сү. Засаг даргын тамгын газар	7,850,774.5	6,800,357.3	1,050,417.2	86.6
3	Сэ. Сү. Ойн анги	256,098.1	214,380.8	41,717.3	83.7
4	Сэ. Сү. Орон нутгийн хөгжлийн сан	1,236,248.8	883,976.5	352,272.3	71.5
5	Сэ. Сү. Сум хөгжүүлэх сан	302,100.0	89,689.4	212,410.7	29.7
6	Сэ. Сү. 1-р сургууль	406,000.0	405,999.9	0.1	100.0
7	Сэ. Сү. 2-р сургууль	163,051.8	123,229.1	39,822.7	75.6
8	Сэ. Сү. 3-р сургууль	194,564.6	191,951.5	2,613.1	98.7
9	Сэ. Сү. 4-р сургууль	178,800.0	178,799.0	1.0	100.0
10	Сэ. Сү. 5-р сургууль	95,360.0	94,012.4	1,347.6	98.6
11	Сэ. Сү. 6-р сургууль	102,812.5	97,249.1	5,563.4	94.6
12	Сэ. Сү. Спорт сургууль	301,143.0	295,081.4	6,061.6	98.0
13	Сэ. Сү. 1-р цэцэрлэг	78,695.0	78,685.1	9.9	100.0
14	Сэ. Сү. 2-р цэцэрлэг	263,409.7	263,408.8	0.9	100.0
15	Сэ. Сү. 3-р цэцэрлэг	160,913.5	160,913.5	-	100.0
16	Сэ. Сү. 4-р цэцэрлэг	135,963.3	135,962.6	0.7	100.0
17	Сэ. Сү. 5-р цэцэрлэг	88,914.0	88,914.0	-	100.0
18	Сэ. Сү. Хүүхдийн ясли	43,336.9	35,755.5	7,581.4	82.5
19	Сэ. Сү. 7-р цэцэрлэг	104,500.0	81,566.0	22,934.0	78.1
20	Сэ. Сү. 8-р цэцэрлэг	60,882.7	60,827.4	55.3	99.9
	Нийт дүн	12,598,412.2	10,824,934.5	1,773,477.7	85.9

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 9,839,397.6 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 28207.1 мянган төгрөг, ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс 83,833.5 мянган төгрөг, ОНХС-аас 990,258.0 мянган төгрөг нийт **10,941,696.2** мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **10,824,934.5** мянган төгрөг буюу **85.9** хувьтай байгаа нь урсгал зардлыг 458,955.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,104,001.5 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 210,520.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 271,538.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 84,425.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 8,150.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 9,845.3 мянган төгрөг, томилолт, зочны зардал 7,950.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 11,303.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 13,566.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 52,175.3 мянган төгрөг зэрэг нийт 458,955.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 44 төсөл, арга хэмжээнд 4,147,284.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 40 төсөл, арга хэмжээнд 3,043,283.1 мянган төгрөг олгож, 1,104,001.6 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.

ХХС-аас 300,000.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч зээл зээл олгогдоогүй байна. *Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын ахлах байцаагчийн 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 05/32-01 дугаар төлбөрийн актаар тогтоосон зээлийн алдангийг нөхөн төлүүлэх 178,958.7 мянган төгрөгийн төлбөрийн 50 хувь болох 89,479.4 мянган төгрөгийг сангийн эх үүсвэрээс барагдуулж, 210,520.7 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд сумын ЗДТГ-ийн нэмэлт санхүүжилтийн 100131455408 дугаар дансанд аймгийн ЗДНХ-өөс 3,789.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 810.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 6,395.0 мянган төгрөг зэрэг нийт 10,994.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын ОНХС, ОНХО, урсгал зардлын төсвөөс нийт 4,189,929.3 мянган төгрөгийн 45 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний дагуу өмнөх оноос шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээг хасаж, 3,949,422.1 мянган төгрөгийн 41 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэх 8, харьцуулалтын аргаар гүйцэтгэх 15, гэрээ шууд байгуулах аргаар 18, нийт 41 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан боловч “Худаг барих / 8-р баг” 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгараагүй байна. Үүнд:

Хүснэгт 10. Сүхбаатар сумын 2024 оны худалдан авах ажиллагааны тайлан:

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			Гэрээ шууд байгуулах		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХО	29.0	2,901,035.9	12.0	230,535.9	11.0	745,500.0	6.0	1,925,000.0
Сумын ОНХС	10.0	985,741.6	5.0	90,857.2	3.0	244,884.4	2.0	650,000.0
Урсгал зардал	1.0	42,644.6			1.0	42,644.6		
Дүн	40.0	3,929,422.1	17.0	321,393.1	15.0	1,033,029.0	8.0	2,575,000.0

Эх сурвалж: tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 01/101 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 9,617,785.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 96,177.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах **35,759.6** мянган төгрөгийн зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. Сумын ИТХ: Батлагдсан төсвөөс дараах **25,250.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг хийж, гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Вишн Визуал студи ХХК-аар ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааг сурталчилсан контент, дүрс бичлэг бэлтгүүлсний төлбөрт **20,000.0** мянган төгрөгийг төлсөн,
- Бэлэг дурсгалын зориулалт бүхий **5,250.0** мянган төгрөгийн 1.5 мянган ширхэг цаасан тор бэлтгэж, ашиглалтгүй илүүдэл нөөц бүрдүүлсэн байна.

2. ЗДНХ: Сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн боловч хүлээн аваагүй байна.

3. Сумын ЗДТГ: ИТХ-ын хүндэтгэлийн хуралдаанд зориулан **2,500.0** мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.4: ... аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.5: төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах, 15.1.6: ... бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 11. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	178	174	4
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	177	174	3
3	Сумын Засаг даргын Тамгын газар	177	176	1
	Нийт дүн	532	524	8

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

1. Тайлант хугацаанд Сүхбаатар сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 27-29 төрлийн нийт 532 мэдээллээс 524 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өмнөх аудитаар 16 мэдээллийг хугацаа хоцроосон, 12 мэдээллийг огт мэдээлээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Сумын ИТХ: Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас зайлсхийж, шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт багтаах зорилгоор **22,000.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн тайлан”-г эх бэлтгэл, хэвлэлт гэж 2 хуваан төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, Засгийн газрын 2024 онд 02 дугаар “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоолын Хавсралтын 1 дэх: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар - Бараа 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудас хөтлөлт, худалдан авах ажиллагаа нь Шилэн дансны тухай, ТБОНӨХБАУХА тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 172 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,950.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 36,301.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 78,510.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжөөс “Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж бүртгээгүй” зөрчилд өгөгдсөн зөвлөмжийг биелүүлээгүй байна. Үүнд:

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,950.0	2	1,950.0	100
Албан шаардлага	3	36,301.9	3	36,301.9	100
Зөвлөмж	5	78,510.0	4	78,510.0	80
Нийт дүн	10	116,761.9	9	116,761.9	90

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2022, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **16,171,256.2** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 14,413,114.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,758,141.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдааг залруулах зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны устгалыг татаагүйгээс санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн нийт **14,413,114.8** мянган төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого, зарлагыг тус бүр 7,206,557.4 мянган төгрөгөөр илүү,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлого, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг тус бүр 7,206,557.4 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Залруулаагүй алдаа:

- ХХС-ийн санхүүгийн тайлангийн авлагын тодруулгад 871,179.8 мянган төгрөгийн зээл, 67,784.6 мянган төгрөгийн зээлийн хүүгийн нийт 938,964.4 мянган төгрөгийн авлагын насжилтыг зөрүүтэй бүртгэсэн,
- ЗДТГ нь бусад үндсэн хөрөнгийн дансанд 819,177.0 мянган төгрөгийн газрыг бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэл тайланд насжилт зөрүүтэй тусгасан авлага, ангилал зөрүүтэй бүртгэсэн хөрөнгийг 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **359,787.4** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **9,765.6** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **303,906.2** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **46,115.6** мянган төгрөгийн зөрчлийг арилгах **4** зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт:

Сумын ИТХ:

1. ИТХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг арга хэмжээний батлагдсан төсвөөс **2,000.0** мянган төгрөгийг сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан төлөөлөгч Г.Амарбаясгаланд олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй олгосон дэмжлэгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Цалингийн батлагдсан төсвөөс ажлын албаны мэргэжилтэн М.Оюунсүрэнд **800.0** мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг тооцож, олгосон боловч гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөнгөлөлтийг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Сумын ЗДТГ:

3. Албан хаагчдад олгосон урамшууллаас ХХОАТ суутгаагүй болон цалин, хөнгөлөлтийг илүү тооцож олгосон дараах 6,965.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “*Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам*”-ын дагуу орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны 2 албан хаагчид олгосон 10,115.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татвар **1,011.5** мянган төгрөгийг суутгаагүй,
- Тайлант оны 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухайн үеийн үндсэн цалингаас бус 4 дүгээр сард нэмэгдсэн цалингаас тооцож, 39 албан хаагчид **2,654.1** мянган төгрөгийг илүү олгосон,
- Цалингийн батлагдсан төсвөөс 10 албан хаагчид нийт **3,300.0** мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг тооцож, олгосон.

Эдгээр нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “*Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.1: цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.*” 20.2.5 дахь “*... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалин, хөнгөлөлт, ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Төлбөр, тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **4,129.6** мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг*

заавал бүртгэнэ: 14.4.2: бүх хөрөнгө, ... авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, **авлага ба төлбөрийн тооцоог хянах**, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3.7 (г) дахь “зардлыг урьдчилан төлөх үед: Дт.Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/, Кт.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Үүнд:

- Сумын ИТХ: **1,610.0** мянган төгрөгийн самбарын төлбөрийг 2 удаа давхардуулан шилжүүлж, байгууллагаас авах авлага,
- ГХУСЗ-ийн 2024 оны батлагдсан төсвөөс 2025 оны сурталчилгааны самбарын түрээсийн **2,250.0** мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж авлага үүсгэсэн атал урьдчилж гарсан зардлаар бус тайлант жилийн зардлаар тайлагнасан,
- Сумын ЗДТГ: **269.6** мянган төгрөгийн НДШ-ийн авлага.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Сумын ИТХ:

2. Батлагдсан төсвийг зориулалт бусаар үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан **56,163.8** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан 42,969.0 мянган төгрөг.

- Төлөөлөгчдийн хоолны зардлыг бодит ирцээр бус нийт төлөөлөгчдийн тоогоор тооцож, 809.2 мянган төгрөг илүү зарцуулсан,
- ЭБАТ-ны нэмэгдлийг тогтоосон хэмжээнээс илүү тооцож, ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Гантулгад 2,776.8 мянган төгрөгийг илүү олгосон,
- ГХУСЗ-ийн батлагдсан төсвөөс сургалт, хэлэлцүүлгийн зардалд нийт **39,383.0** мянган төгрөгийн гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, хүрсэн үр дүнг тооцоогүй байна. Үүнд:
 - Сургагч багш бэлтгэх зорилгоор сургалт зохион байгуулж, багшийн төлбөр, хоолны зардалд 14,489.0 мянган төгрөгийг шилжүүлж, сургагч багшийг бэлдсэн ч бэлтгэгдсэн сургагч багш нараас иргэд рүү чиглэсэн сургалт, нөлөөллийн арга, хэмжээ зохион байгуулаагүй, үр дүн тодорхойгүй,
 - “Сүхбаатар суманд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, хүүхдийг гэмт хэргээс хамгаалах урьдчилан сэргийлэх зураглал” сэдэвт судалгааны ажлыг гэрээний дагуу Эерэг өөрчлөлтийг хамтдаа НҮТББ-аар хийлгүүлж, 10,000.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч уг судалгааг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, тайлагнаагүй, ашиглалт, үр дүн тодорхой бус,
 - “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй”, “Хамтарсан багийн чадавхжуулах сургалт” гэх мэт сургалт хэлэлцүүлэг, нөлөөллийн зардалд 8,394.0 мянган төгрөг,

сурталчилгааны самбарын түрээс, бичлэг хийлгэх зардалд 6,500.0 мянган төгрөгийн төлбөрийг гүйцэтгэсэн боловч гэрээг дүгнээгүй, үр дүн тодорхой бус.

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан 13,194.8 мянган төгрөг.

- Бараа үйлчилгээний бусад зардлаас багаж, техник хэрэгслийн зардалд 6,804.8 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,237.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 1,323.0 мянган төгрөг, томилолтын зардалд 1,130.0 мянган төгрөг зэрэг нийт **10,494.8** мянган төгрөг,
- ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал 2,700.0 мянган төгрөгийг харилцагч байгууллагад бус бусад хамааралгүй аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлсэн.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.8 дахь “Төлөөлөгчийн зардлыг бэлнээр олгохгүй бөгөөд үнийн нэхэмжлэх болон бусад баримтыг үндэслэн зардлын хязгаарт багтаан холбогдох санхүүжилтийг тухайн байгууллагад шилжүүлнэ”, аймгийн ИТХ-ын 2022 оны 208 дугаар “Сумдын ИТХ-ын дарга нарт” албан бичгээр хүргүүлсэн “ЭБАТ-ны нэмэгдлийг аймгийн Засаг даргын захирамжийг¹ жишиг болгон мэдүүлэг гаргагчдын тоонд харгалзуулан тогтоон өгч байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдаагүй атал төлөөлөгчид санал гаргаж, хэлэлцэн, баталсан гэх үндэслэлээр сумын ИТХ-д суудалтай 2 намд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр нэг суудлыг 2,000.0 мянган төгрөгөөр тооцон нийт 62,000.0 мянган төгрөгийг төлөвлөж, **12,000.0** мянган төгрөгийн санхүүжилтийг Ардчилсан намд олгосон байна.

Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх “Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 10.1.5: Энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс ... **санхүүжилт** шууд болон шууд бусаар авах”, 34 дүгээр зүйлийн 34.6.3: “Төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Аймгийн Засаг даргын 2022 оны Б/14 дүгээр “Цалингийн нэмэгдлийн хувийг шинэчлэн тогтоох тухай” захирамжийн хавсралтаар баталсан “Цалингийн нэмэгдлийн хувийг тогтоосон хүснэгт”-ийн 3-д “Сүхбаатар сумын ЗДТГ-25%”,

Шийдвэрлэсэн нь: Улс төрийн намуудад төсвийн хөрөнгөөр санхүүжилт олгохгүй байх албан шаардлага хүргүүлэв.

ЗДНХ:

4. ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс дараах 170,344.7 мянган төгрөгийн зориулалт бус зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- ✓ *Жил бүр давтагддаг, урьдчилан төлөвлөх боломжтой цэрэг татлагын зардалд 2,600.8 мянган төгрөг, мал тооллогод 2,916.2 мянган төгрөг, нохой устгалд 20,180.0 мянган төгрөг, муур унтуулгад 7,362.5 мянган төгрөг, хүүхдийн баярт 14,283.5 мянган төгрөг, хамтарсан багийн зардалд 9,079.9, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээнд 54,745.0 мянган төгрөг, нийтийг хамарсан ажилд 13,975.6 мянган төгрөг зэрэг нийт **125,143.5** мянган төгрөг,*
- ✓ **Төсвийн байгууллагын өөрийн батлагдсан төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой 37,962.5 мянган төгрөгийн дараах урсгал зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:**
 - *1 дүгээр сургууль 5,085.0 мянган төгрөг, /тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн төвд дэмжлэг 2,485.0 мянган төгрөг, биеийн тамирын заал барих ажлын геологийн дүгнэлт гаргах ажилд дэмжлэг 2,600.0 мянган төгрөг/*
 - *Спорт сургууль 2,500.0 мянган төгрөг /Бэлчир бүсийн багш нарын спортын олон төрөлт тэмцээнд дэмжлэг/*
 - *4 дүгээр цэцэрлэг 7,890.0 мянган төгрөг /гамшгийн үеийн материал, хаалт, будаг, шруп 5,280.0 мянган төгрөг, 80 жилийн ойд өргөмжлөлийн зардал 2,610.0 мянган төгрөг/*
 - *Онцгой байдлын газар 10,000.0 мянган төгрөг,/ Аврах 36-р ангид самбар байршуулах, тараах материал хэвлүүлэхэд 8,000.0 мянган төгрөг, ОБГ-ын ойд материалын дэмжлэг 2,000.0 мянган төгрөг/*
 - *Хилийн цэргийн 0101 дүгээр анги 3,787.5 мянган төгрөг,/ Хил хамгаалах хилийн бүс орчимд анхааруулга самбарын үнэ/*
 - *Цагдаагийн газар 2,000.0 мянган төгрөг, /Цагдаагийн газрын 100 жилийн ойд самбар хийх/*
 - *Өрхийн эрүүл мэндийн төв 5,000.0 мянган төгрөг, ӨЭМТ-ийн эмч нарт 0-5 настай хүүхдийн эрт илрүүлгийн зардалд 1,000.0 мянган төгрөг, өрхийн эмч нарын сургалтын зардалд 4,000.0 мянган төгрөг/*
 - *Сумын ЗДТГ 1,700.0 мянган төгрөг./ Бүсчилсэн хөгжил-аймгийн төвийн хотууд туршлага судлахад дэмжлэг/*
- ✓ **Дараах байгууллагуудад худгийн болон бохирын насос, камер худалдан авахад 7,238.7 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:**
 - *Арвин агро нөхөрлөлд 2,000.0 мянган төгрөгийн худгийн насос,*
 - *Сүхбаатар сумын ЗДТГ 5,238.7 мянган төгрөгийн бохирын насос.*

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь “Энэ журмын 1.1-д заасан “урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан” гэдгийг **жил бүр давтагддаггүй** онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно.”, 3 дугаар

зүйлийн 3.1.2 дахь “ Урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар **тоног төхөөрөмж бэлтгэх** хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

Сумын ЗДТГ:

5. Аймгийн Засаг даргын 2015 оны А/475 дугаар захирамжаар батлагдсан орон тоонд батлагдаагүй худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, байгууллагын дотоод ажил, батлан хамгаалах, гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн гэсэн 2 албан хаагчийг томилон **61,268.1** мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээд шатны төсвийн захирагчийн баталсан орон тоог мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

6. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **32** нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нь албан үүргээ хангалтгүй гүйцэтгэснээс төсөв, санхүүтэй холбоотой материаллаг хэмжээний зөрчлүүд илэрсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Гантулгад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар холбоотой асуудал:

Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр, арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэл, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4 “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга”, 54.5.5 “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, үнэн зөв бэлтгэх зөвлөмж өгөв.

2. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Сумын ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг тусад нь зардлын ангилалд тусган батлуулаагүйгээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 1,350.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 29,686.0 мянган төгрөг зэрэг нийт **31,036.0** мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2: Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 42 дугаар зүйлийн 42.2 дахь “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: 42.2.2: төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд”, 42.3.1 дэх “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Жил бүр давтагдан, зайлшгүй гарах зардлуудыг холбогдох төсвийн ангилал, зардлын бүлгээр төлөвлөж, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг ханган ажиллах.

3. Анхан шатны баримттай холбоотой асуудал:

3.1.1 Илрүүлэлт: Сумын ОНХО-ийн батлагдсан төсвөөс хэрэгжүүлсэн “Явган хүний зам талбай, гарц, гэрэлтүүлэг, тохижилт Баянхан 4, 2, 5-р баг, 6-р баг”,

“Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх 1-8-р баг” 2 төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардлыг төсөв, фото зургаар баталгаажуулаагүйгээр **15,079.6** мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.17 дахь “Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, **магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл, холбогдох норм, дүрэмд заасныг үндэслэн Барилгын төсөв зохиох дүрэмд заасан хавсралтын дагуу баталгаажуулан ирүүлснийг үндэслэн олгоно**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Өгсөн зөвлөмж: Магадалшгүй ажлын зардлыг журмын дагуу тооцож, олгож байх.

3.2.1 Илрүүлэлт: ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс хэрэгжүүлсэн арга хэмжээний зарцуулалтын тайланг төсөвтэй нь зэрэгцүүлэн хянаж, хугацаанд нь хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан эсэх, хэмнэлт гарсан эсэхийг тооцож, тодорхойлоогүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна.

3.2.2 Өгсөн зөвлөмж: ЗДНХ-ийн зарцуулалтын тайланг тогтоосон хугацаанд нь хянаж, хүлээн авах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сумын ТТЗ	2	15,352,079.2			2	15,352,079.2	1	14,413,114.8	1	938,964.4	1	938,964.4
Сумын ЗДТГ	1	819,177.0			1	819,177.0			1	819,177.0	1	819,177.0
Дүн	3	16,171,256.2			3	16,171,256.2	1	14,413,114.8	2	1,758,141.4	2	1,758,141.4

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ТТЗ	4	185,424.3			1	170,344.7	3	15,079.6				
Сумын ИТХ	7	105,859.8	2	2,800.0	3	72,023.8	1	31,036.0	1	1		
Сумын ЗДТГ	4	68,503.3	2	6,965.6	2	61,537.7						
Дүн	15	359,787.4	4	9,765.6	6	303,906.2	4	46,115.6	1	1		

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс			
	Телберийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Сумын ТТЗ	1	-	1	-		
Дүн	1	-	1	-		
ТБОНӨХБАУХАТ хуулийн хэрэгжилт						
Сумын ИТХ	1	22,000.0	1	22,000.0		
Дүн	1	22,000.0	1	22,000.0		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт						
Сумын ИТХ	1	25,250.0	1	25,250.0		
Сумын ЗДТГ	1	2,500.0	1	2,500.0		
Сумын ТТЗ	1	4,879.6	1	4,879.6		
Дүн	3	32,629.6	3	32,629.6		
Нийт дүн	5	54,629.6	5	54,629.6		